

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК -ИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” /ХХНОБ/ ТӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ХХНОБ ТӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 97.6%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ХХНОБ ТӨХХК-ийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
19	17	2	1	-	-	-	-	97.3%

2.2. Сайдын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%			
1	1	-	-	-	-	-	100%

2.3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%			
Төсөв/гүйцэтгэл	6	6	-	-	-	-	-	100,0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	6	-	-	-	-	-	100,0
бусад	8	8	-	-	-	-	-	100,0
Нийт	20	20	-	-	-	-	-	100,0

2.4. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамаа ралгүй	
Нийт	46	24	4	-	-	18	95,7%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

ХХНОБ ТӨХХК нь ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 97.6%-тай байна.
- 2) 2024 онд “Чингис хаан” ОУНБ нь “4 STAR AIRPORT” зэрэглэл авч, олон улсын ирэгчийн ашигтай зай талбайг 34м², олон улсын ирэх, явах зорчигч, угтагчид зориулан терминалын ашигтай талбайг нийт 292 м2, олон улсын бүртгэлийн цэгийг 14-өөр нэмэгдүүлж, нисэх буудлын хүлээн авах нэвтрүүлэх чадварыг сайжирснаар олон улсын 1,761,063 зорчигч, орон нутгийн 423,679 зорчигч, нийт 2,184,742 зорчигчийг саадгүй хүлээн авч ажиллажээ.
- 3) ХХНОБ ТӨХХК нь өмнөх онд өөрийн орлогын зөвхөн нэг эх үүсвэр буюу Хүндэт зочны танхимын үйлчилгээнээс орлого олж, алдагдалтай ажиллаж байсан бол тайлант оноос эхлэн Хувьцаа эзэмшигчийн үйл ажиллагаанаас орлого олж эхэлснээр үндсэн үйл ажиллагаанаас олох өөрийн орлогын эх үүсвэр нэмэгдсэн байна. 2024.12.31-ны өдрийн гүйцэтгэлээр Төрийн хүндэт зочны танхимаас 1.0 тэрбум төг, бусад орлогоос 1,2 тэрбум төгрөг, Хувьцаа эзэмшигчийн үйл ажиллагааны /ногдол ашиг/ орлого 16,4 тэрбум төгрөг, нийт 18.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, ашигтай ажилласан.
- 4) Төрийн хүндэт зочны танхимын үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой, хэвийн явуулж, “Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”-ын дагуу нийт 2,185 зөвшөөрлийн хуудсаар 8,114 зорчигч, үйлчлүүлэгчдийг угтан авч, үдэн гаргах үйлчилгээ үзүүлэн, танхимын үйлчилгээнээс 1.136,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн төлөвлөгөөгөө 100% биелүүлсэн байна.
- 5) 2024 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн “АНУ руу шууд нислэг үйлдэхэд шаардлагатай бэлтгэл ажлыг хангуулах, нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах зэрэг хугацаа хоцорч байгаа ажлуудаа 2024 оны III улиралд багтаан дуусгах” зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Чингис хаан” ОУНБ-ыг өргөтгөх, цаашид олон улсын агаарын ачаа тээврийн транзит төв болгон өргөжүүлэх чиглэлээр судалгааны ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагч талд тавьж шийдвэрлүүлэх;
2. АНУ руу шууд нислэг үйлдэхтэй холбоотой хийгдсэн TSA-ийн шалгалтаар “Чингис хаан” ОУНБ-д одоо хэрэглэгдэж байгаа, үзлэг шалгалтын зарим төхөөрөмжүүдийг шинэчлэх зөвлөмж өгсөний дагуу шаардлагатай тоног

төхөөрөмжүүдийг худалдан авах санхүүжилтийг шийдвэрлэн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

3. Чингис хаан” ОУНБ-ын дэргэд “Транзит зочид буудал” барих болон МИАТ ХХК-ийн Карго ачаа, шуудан дамжин өнгөрүүлэх терминалын барилга, газрын тусгай үйлчилгээний техник, тоног төхөөрөмж, автомашин байрлуулах гражийн барилга барих ажилд дэмжлэг үзүүлэн ажиллах;
4. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;
5. Компанийн худалдан авах ажиллагаанд аудит, хяналт, шалгалт хийж, тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг Шилэн дансанд мэдээлэх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР